



ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 02 сарын 06 өдөр

Дугаар А/49

Эрдэнэт

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1, 29.2, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.3, аймгийн Засаг даргын 2013 оны А/619 дүгээр захирамжаар баталсан “Захиргааны байгууллагын Хяналт-шинжилгээ, үнэлгээний нийтлэг журам”-ын 23 дугаар зүйлийн 23.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Захиргааны байгууллагуудын 2016 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх, арга зүйн зөвлөгөө өгөх ажлын хэсгийг I, ажиллах хуваарийг II, шаардагдах зардлын тооцоог III хавсралтаар тус тус баталсугай.

2. Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг аймгийн Засаг даргын 2013 оны А/619 дүгээр захирамжаар баталсан журмын дагуу явуулж 2017 оны 03 дугаар сард багтаан аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхийг Ажлын хэсэг /н.Соёлчхүү/-т даалгасугай.

3. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хуулийн талаар болон Захиргааны байгууллагуудын 2016 оны Үйл ажиллагаанд хийгдсэн Хяналт-шинжилгээ, үнэлгээтэй холбогдуулан арга зүйн зөвлөгөө өгөх, албан хаагчдын мэдлэг чадвар болон үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, гүйцэтгэлийн үнэлгээг тооцох чиглэлээр сургалт зохион байгуулахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын хэлтэс /н.Жанболат/-т үүрэг болгосугай.

4. Дээрх арга хэмжээнүүдэд шаардагдах 3228400 /Гурван сая хоёр зуун хорин найман мянга дөрвөн зуун/ төгрөгийн аймгийн Засаг даргын бусад зардал /Хяналт-шинжилгээ, үнэлгээ зохион байгуулах /-аас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Д.БАТЛУТ

D:(Zahiramj) A-4 doc

07000 319

Аймгийн Засаг даргын 2017 оны 02 дугаар сарын
06 өдрийн 4112 дугаар захирамжийн III хавсралт

**ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭНИЙ АЖЛЫН
ЗАРДЛЫН ТӨСӨВ**

№	Зардлын зориулалт	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1.	Хотын дотор өдөрт 50 км х 4 машин /7 өдөр/	250км х 70лх1660	116200
2.	Жаргалант сум 60 км х 4 машин	180 км х 70 л х1660	116200
3.	Хоолны зардал 13 хүн*7 өдөр	40000	520000
4	Бичиг хэргийн зардал		800000
5	Сургалт зохион байгуулах зардал		
	а/ цай	2600х2х80 хүн	416000
	б/ Ус	80 х750	60000
	в/ Өдрийн хоол	80х15000	1200000
	Бүгд		3228400

00